



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1,6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан нийт 69,110,754,495.00 (жаран есөн тэрбум нэг зуун арван сая долоон зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуун ерэн таван) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны
өдрийн дугаар тогтоолын
хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН, ТӨРИЙН ӨМЧИД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламж /хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ/-ний нэр	Ашиглалтад орсон он	Хөрөнгийн нийт үнэ (төгрөг)	Хүлээн авах байгууллага
1	Баянхонгор-Арвайхээр чиглэлийн авто замын огцом эргэлтийг өөрчлөх, хатуу хучилттай авто зам, 4.4 км /Баянхонгор, Өлзийт сум/	2020	3,276,679,615.00	Зам, тээврийн хөгжлийн яам
2	Гашууны голын төмөр бетон гүүрийн их засвар, 72.0 у/м /Увс, Улаангом сум/	2020	2,094,286,989.00	Зам, тээврийн хөгжлийн яам
3	Гурванбулаг-Хишиг-Өндөр чиглэлийн авто замын төгсгөлийн хатуу хучилттай авто зам, 22 км /Булган/	2019	20,222,300,000.00	Зам, тээврийн хөгжлийн яам
4	Ноён сумаас Сухайт хүртэлх сайжруулсан шороон зам, 20 км /Өмнөговь, Ноён сум/	2020	8,995,696,065.00	Зам, тээврийн хөгжлийн яам
5	Онон голын төмөр бетон гүүр, 150.0 у/м /Хэнтий, Баян-Адрага сум/	2020	4,489,603,355.00	Зам, тээврийн хөгжлийн яам
6	Онон голын төмөр бетон гүүрийн засвар, 238.9 у/м /Хэнтий, Дадал сум/	2020	2,585,928,584.00	Зам, тээврийн хөгжлийн яам
7	Онон голын төмөр бетон гүүрийн 238.9 у/м гүүрийн зураг			Зам, тээврийн хөгжлийн яам
8	Орхон-Хишиг-Өндөр сум чиглэлийн хатуу хучилттай авто замын эхлэл /Булган/	2020	9,555,099,116.00	Зам, тээврийн хөгжлийн яам
9	Чингис хот-Бэрх чиглэлийн аялал хатуу хучилттай авто замын эхлэл, 20 км /Хэнтий/	2019	17,391,160,771.00	Зам, тээврийн хөгжлийн яам
10	Дэглий цагаан нисэх онгоцны буудлын явгалах замын өргөтгөл /Увс, Улаангом сум/	2019	500,000,000.00	Иргэний нисэхийн ерөнхий газар
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		69,110,754,495.00 (жаран есөн тэрбум нэг зуун арван сая долоон зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуун ерэн таван)	